



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 06 өдөр

Дугаар A/283

Мөрөн сүм

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх  
арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх  
ажлын жагсаалт, төсөвт өртөг батлах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны IX хуралдааны 05 дугаар тогтоол, 2022 оны ээлжит бус XIII хуралдааны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Байгаль орчныг орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төрөл бүрийн модны үрийн нөөц бүрдүүлэх” ажлын төсөвт өртгийг нэгдүгээр, “Ойн санг гэрээгээр эзэмшин хамгаалж буй нөхөрлөл, ААНБ-ыг урамшуулах” ажлын төсөвт өртгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинзорогдог)-т, болзолт уралдаан зарлан үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тайлagnаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН



Аймгийн Засаг даргын 2022 оны 09  
дүгээр сарын 05.-ны өдрийн .... А/28 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

“ТЭРБУМ” МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД  
ТӨРӨЛ БҮРИЙН МОДНЫ ҮРИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ТӨСӨВ

№	Үйл ажиллагаа	Шаардагдах хөрөнгө /сая.төг/
1	Төрөл бүрийн модны үрийн нөөц бүрдүүлэх	57,600,000
	Нийт дүн	57,600,000

\_\_\_\_\_ооо\_\_\_\_\_

Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр  
сарын 06.-ны өдрийн .... А/2.8.3. дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

ОЙН САНГ ГЭРЭЭГЭЭР ЭЗЭМШИН ХАМГААЛЖ БАЙГАА  
ИРГЭН, ОЙН НӨХӨРЛӨЛ, ААНБ-ЫГ УРАМШУУЛАХ АЖЛЫН ТӨСӨВ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Төсөвт өртөг /мян.төг/
1	Ойн санг гэрээгээр эзэмшин хамгаалж байгаа иргэн, ойн нөхөрлөл, ААНБ-ыг урамшуулах	4,400,000
	Нийт дүн	4,400,000

\_\_\_\_\_ооо\_\_\_\_\_